ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.02.24 № 248

танай 2025.01.15 -ны № 19/25 -т

ДОРНОД АЙМГИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Д.ОЮУНБАЯР ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд танай байгууллагын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, санал дүгнэлтийг хүргүүлж байна.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

2125030132

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.02.24 № 249
танай 2025.01.15-ны № 19/35-т

ДОРНОД АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Д.ОЮУНБАЯР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Дорнод аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилго, 7 зорилтын хүрээнд 33 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газраас 92.0 хувьтай үнэлсэн байна.

01102?0?8

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ДОА-2025/046/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Чойбалсан хот<br>2025 он | Дорнод аймаг дахь Төрийн аудитын дарга,<br>Тэргүүлэх аудитор: Б.Болортуул<br>Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn<br>Аудитын менежер: И.Сэмжидмаа<br>Утас: 7058-4207 Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Нармандах<br>Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn<br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК<br>Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг<br>Утас: 88883776 Цахим хаяг:khaanconsultingaudit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ..... 2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ..... 4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ..... 10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ..... 10
3.2 Байгууллагаын гадаад, дотоод орчин ..... 10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ..... 11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 11
4. АУДИТЫН ТАЙЛАН ..... 12
4.1 Ерөнхий зүйл ..... 12
4.2 Материаллаг байдал ..... 13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ..... 13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 14

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| УИХ | Улсын Их хурлын сонгууль |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр Утас/Факс 7058-4203

2025.02.24 № 249

танай 2025.01.15 -ны № 19/35 -т

ДОРНОД АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Д.ОЮУНБАЯР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Дорнод аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилго, 7 зорилтын хүрээнд 33 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газраас 92.0 хувьтай үнэлсэн байна.

01102 2025

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **56,107,990.05** | **78,813,382.45** |
| **31** | **МӨНГӨН БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ** | **3,854,759.59** | **12,983,015.59** |
| **312** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | **3,854,759.59** | **12,983,015.59** |
| **3121** | **Төгрөг** | **3,854,759.59** | **12,983,015.59** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 3,854,759.59 | 12,983,015.59 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 52,253,230.46 | 65,830,366.86 |
| **351** | **Түүхий эд материал** | 25,006,925.75 | 31,838,024.15 |
| 35110 | Тусгай зориулалтын материал | 25,006,925.75 | 31,838,024.15 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 10,988,190.00 | 11,447,150.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 16,258,114.71 | 22,545,192.71 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 967,794.00 | 3,895,282.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 11,221,349.71 | 14,695,739.71 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 289,000.00 | 289,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 188,972.00 | 4,172.00 |
| 3547003 | Бусад хангамжийн материал | 3,590,999.00 | 3,660,999.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **168,723,961.79** | **149,290,018.14** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **168,723,961.79** | **149,290,018.14** |
| **392** | **Биет хөрөнгө** | 151,223,961.79 | 131,790,018.14 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 33,000,000.00 | 33,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (33,000,000.00) | (33,000,000.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 346,873,429.63 | 359,427,309.63 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (210,725,411.85) | (240,937,588.88) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 32,710,180.00 | 32,910,050.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (17,634,235.99) | (19,609,752.61) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 17,500,000.00 | 17,500,000.00 |
| 39301 | Программ хангамж | 13,077,732.76 | 13,077,732.76 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (13,077,732.76) | (13,077,732.76) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 17,500,000.00 | 17,500,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **224,831,951.84** | **228,103,400.59** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **61,990.00** | **-** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 61,990.00 | - |
| **413** | **Өглөг** | 61,990.00 | - |
| 4132 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 61,990.00 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **224,769,961.84** | **228,103,400.59** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **224,769,961.84** | **228,103,400.59** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 152,058,732.55 | 152,058,732.55 |
| 51101 | Өмч: - төрийн | 152,058,732.55 | 152,058,732.55 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **54,799,298.13** | **54,799,298.13** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 54,799,298.13 | 54,799,298.13 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 3,333,438.75 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 17,911,931.16 | 17,911,931.16 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **224,831,951.84** | **228,103,400.59** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **813,689,979.04** | **1,438,521,496.05** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **72,504,879.04** | **30,215,150.83** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **72,504,789.04** | **30,215,150.83** |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 52,196,089.45 | 4,926,340.83 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 16,454,030.00 | 25,288,810.00 |
| 140020 | Бусад орлого | 3,854,759.59 | |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **741,185,100.00** | **1,408,306,345.22** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 736,531,100.00 | 1,202,520,700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | - |
| 131103 | ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс | - | 57,674,145.22 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,654,000.00 | 148,111,500.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **831,461,094.39** | **1,435,188,057.30** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **812,173,254.38** | **1,435,188,057.30** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 795,419,754.38 | 1,238,094,201.14 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 584,583,600.00 | 881,948,051.84 |
| 210101 | Үндсэн цалин | 385,384,290.87 | 435,893,720.10 |
| 210102 | Нэмэгдэл | 148,055,954.68 | 338,869,203.38 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 42,049,458.85 | 79,860,000.00 |
| 210104 | Урамшуулал | 9,093,895.60 | 27,325,128.36 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **74,310,500.00** | **116,447,352.22** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 51,811,100.00 | 81,715,252.22 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,624,800.00 | 8,683,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,499,900.00 | 4,965,937.14 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,125,000.00 | 3,717,062.86 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,249,700.00 | 17,366,100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **19,208,600.00** | **13,950,000.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,701,600.00 | 5,000,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 3,596,947.00 | 3,200,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,500,000.00 | 3,500,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 7,410,053.00 | 2,250,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **20,263,207.00** | **19,234,601.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 8,944,418.00 | 11,289,075.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,600,000.00 | 4,004,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,236,990.00 | 2,312,090.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,481,799.00 | 1,628,636.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **312,000.00** | **2,830,500.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 21,900.00 | - |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 180,000.00 | 620,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 110,100.00 | 2,210,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | 755,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 755,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **24,960,778.00** | **20,199,301.60** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 9,126,300.00 | 6,643,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | 100,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210806 | Мэдээллийн технологийн үйлчилгээ | 4,000,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **71,781,069.38** | **182,729,394.48** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,654,000.00 | 150,105,940.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,053,600.00 | 930,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 66,073,469.38 | 31,693,454.48 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **16,753,500.00** | **197,093,856.16** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 16,753,500.00 | 131,858,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 15,253,524.00 | - |
| 213208 | Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 128,189,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,499,976.00 | 3,669,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 65,235,856.16 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 65,235,856.16 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(17,771,115.35)** | **3,333,438.75** |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ | 19,287,840.01 | - |
| 225010 | Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө | 19,287,840.01 | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(17,771,115.35)** | **3,333,438.75** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **766,209,436.25** | **1,669,366,984.72** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **244,153,736.25** | **261,060,639.50** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **244,153,736.25** | **261,060,639.50** |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **244,153,736.25** | **250,223,543.50** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 244,153,736.25 | 250,223,543.50 |
| 1200009 | Бусад орлого | | 10,837,096.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **522,055,700.00** | **1,408,306,345.22** |
| | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **517,401,700.00** | **1,202,520,700.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 517,401,700.00 | 1,202,520,700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **4,654,000.00** | **205,785,645.22** |
| 131103 | ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс | | 57,674,145.22 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,654,000.00 | 148,111,500.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **745,841,648.04** | **1,652,905,558.72** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **745,841,648.04** | **1,652,905,558.72** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **486,243,887.79** | **1,205,588,159.06** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 403,411,200.00 | 886,045,636.84 |
| 210101 | Үндсэн цалин | 278,045,250.35 | 435,893,720.10 |
| 210102 | Нэмэгдэл | 99,341,490.80 | 338,869,203.38 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 26,024,458.85 | 83,957,585.00 |
| 210103 | Урамшуулал | - | 27,325,128.36 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **48,533,562.79** | **116,447,352.22** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 33,209,262.79 | 81,715,252.22 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,831,100.00 | 8,683,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,064,700.00 | 4,965,937.14 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 766,300.00 | 3,717,062.86 |

| | | | |
|---|---|---|---|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,662,200.00 | 17,366,100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **13,426,845.00** | **20,200,000.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,119,845.00 | 5,500,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 2,057,234.00 | 4,700,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,649,713.00 | 6,000,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 6,600,053.00 | 4,000,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **10,567,420.00** | **18,373,130.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 6,247,551.00 | 10,320,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,125,000.00 | 3,550,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,729,040.00 | 2,688,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 155,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,465,829.00 | 1,660,130.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **47,300.00** | **4,066,700.00** |
| 210601 | Багаж техник хэрэгсэл | - | 226,700.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | - | 620,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 47,300.00 | 3,220,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **-** | **755,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 755,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **4,924,960.00** | **8,950,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 924,960.00 | 8,850,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | | 100,000.00 |
| 210806 | Мэдээлэл технологийн үйлчилгээ | 4,000,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **5,332,600.00** | **150,750,340.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,654,000.00 | 149,820,340.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 678,600.00 | 930,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **259,597,760.25** | **447,317,399.66** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 15,453,424.00 | 131,858,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 15,253,524.00 | - |
| 213208 | Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 128,189,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 200,000.00 | 3,669,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **244,144,236.25** | **315,459,399.66** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 65,235,856.16 |
| 213306 | Төвлөрүүлэх шилжүүлэг /УТО/ | 244,144,236.25 | 250,223,543.50 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **20,367,788.21** | **16,461,426.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **3,652,000.00** | **7,333,170.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **3,652,000.00** | **7,333,170.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **3,652,000.00** | **7,333,170.00** |
| | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 3,652,000.00 | 7,333,170.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(3,652,000.00)** | **(7,333,170.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **16,715,788.21** | **9,128,256.00** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **3,854,759.59** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **16,715,788.21** | **12,983,015.59** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **152,058,732.55** | **17,911,931.16** | **54,799,298.13** | **224,769,961.84** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **152,058,732.55** | **17,911,931.16** | **54,799,298.13** | **224,769,961.84** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 3,333,438.75 | 3,333,438.75 |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **152,058,732.55** | **17,911,931.16** | **58,132,736.88** | **228,103,400.59** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **11000** | **Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл** | **-** | **-** | **-** |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,070,662,700.00** | **1,005,426,843.84** | **65,235,856.16** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,070,662,700.00** | **1,005,426,843.84** | **65,235,856.16** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,070,662,700.00** | **1,005,426,843.84** | **65,235,856.16** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **899,844,400.00** | **841,348,054.84** | **65,235,856.16** |
| 210101 | Үндсэн цалин | 453,569,000.00 | 434,380,108.10 | 19,188,891.90 |
| 210102 | Нэмэгдэл | 332,555,400.00 | 295,685,233.38 | 36,870,166.62 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 102,300,000.00 | 83,957,585.00 | 18,342,415.00 |
| 210104 | Урамшуулал | 11,420,000.00 | 27,325,128.36 | (15,905,128.36) |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **110,210,300.00** | **110,210,300.00** | |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 75,478,200.00 | 75,478,200.00 | |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,683,000.00 | 8,683,000.00 | |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,341,500.00 | 4,341,500.00 | |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,341,500.00 | 4,341,500.00 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 17,366,100.00 | 17,366,100.00 | |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **20,200,000.00** | **14,220,000.00** | **5,980,000.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,500,000.00 | 5,000,000.00 | 500,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 4,700,000.00 | 3,200,000.00 | 1,500,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,000,000.00 | 3,500,000.00 | 2,500,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 4,000,000.00 | 2,520,000.00 | 1,480,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **16,573,000.00** | **18,046,049.00** | **(1,473,049.00)** |
| 210401 | Бичиг хэрэг | 10,320,000.00 | 10,319,963.00 | 37.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,550,000.00 | 3,550,000.00 | (2,000,000.00) |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,688,000.00 | 2,374,080.00 | 313,920.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 155,000.00 | | 155,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,860,000.00 | 1,802,006.00 | 57,994.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,700,000.00** | **5,473,300.00** | **(1,773,300.00)** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,860,000.00 | 1,633,300.00 | 226,700.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 620,000.00 | 620,000.00 | |
| 210604 | Урсгал засвар | 1,220,000.00 | 3,220,000.00 | (2,000,000.00) |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **755,000.00** | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 755,000.00 | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **18,450,000.00** | **14,444,140.00** | **4,005,860.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 14,350,000.00 | 14,344,140.00 | 5,860.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 100,000.00 | 100,000.00 | - |
| 210806 | Мэдээллийн технологийн үйлчилгээ | 4,000,000.00 | - | 4,000,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 930,000.00 | 930,000.00 | - |
| **210902** | Хичээл үйлдвэрийн дадлага хийх | 930,000.00 | 930,000.00 | - |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **131,858,000.00** | **131,858,000.00** | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **131,858,000.00** | **131,858,000.00** | - |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **131,858,000.00** | **131,858,000.00** | - |
| 213208 | Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 128,189,000.00 | 128,189,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,669,000.00 | 3,669,000.00 | - |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,202,520,700.00** | **1,202,520,700.00** | - |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,202,520,700.00** | **1,202,520,700.00** | - |

**2.5 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**/төгрөгөөр/**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **57,674,145.22** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **57,674,145.22** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **51,437,093.00** |
| 210101 | Үндсэн цалин | 8,253,123.00 |
| 210102 | Нэмэгдэл | 43,183,970.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **6,237,052.22** |
| 210201 | Нийгмийн даатгалын шимтгэл | 6,237,052.22 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **57,674,145.22** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **57,674,145.22** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 57,674,145.22 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорнод аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд үндэслэн төрийн бодлогын нэгдмэл чанарыг хангах, үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх, улс орны эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлэх, төрийн ой санамжийг бүрдүүлэх, төрөөс иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх улсын бүртгэлийн үйлчилгээг хүртээмжтэй шуурхай хүргэхэд оршино гэх зорилготой чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг, Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа байгууллага юм.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Архивын тухай хууль зэрэг эрх зүйн баримтыг мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

- Иргэний улсын бүртгэлийн хууль
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дорнод аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккуруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Дорнод аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны 229 дүгээр тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн баримталдаг бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3.3 сая төгрөгөөр буюу 1.5 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 3,854.76 | 12,983.02 | 9,128.26 |
| Бараа материал | 52,253.23 | 65,830.37 | 13,577.14 |
| Үндсэн хөрөнгө | 168,723.96 | 149,290.02 | (19,433.94) |
| **Нийт хөрөнгө** | **224,831.95** | **228,103.40** | **3,271.45** |
| Өр төлбөр | 61.99 | - | (61.99) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 224,769.96 | 228,103.40 | 3,333.44 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **224,831.95** | **228,103.40** | **3,271.45** |

Дээрх хүснэгтээс харахад дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлт гарчээ. Үүнд:

Тайлант хугацаанд мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 13.0 сая төгрөг болж 9.1 сая төгрөгөөр өссөн нь төсөвлөсөн зардлаас хэмнэлттэй зарцуулснаас шалтгаалжээ.

Бараа материал дансны үлдэгдэл нь 65.8 сая төгрөг болж 13.5 сая төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн материал болон үнэт цаас / гэрчилгээ, хавтас/-ны үлдэгдэл байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 149.3 сая төгрөг болж өмнөх оноос 19.4 сая төгрөгөөр буурсан нь өөрийн хөрөнгөөр ухаалаг дэлгэц 5.5 сая төгрөг, зөөврийн компьютер 3.7 сая төгрөг, принтер 1.1 сая төгрөгөөр тус тус худалдан авч, тайлант оны элэгдлийн тооцоололтой холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 228.1 сая төгрөг болж өмнөх оноос 3.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүнгээс шалтгаалсан байна.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,070.6 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс 3.8 сая төгрөг, нийт

зарлагыг 1,074.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,202.5 сая төгрөгийн санхүүжилт орсон ба үүнд 131.8 сая төгрөгийн төрийн албанд тасралтгүй 5 жил ажилласан албан хаагчдад олгох мөнгөн урамшуулал багтсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,005.4 сая төгрөг буюу 93.9 хувьтай байгаа нь төсвийг дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **70406** | **Улсын бүртгэл мэдээлэл** | **1,202,520.70** | **1,137,284.84** | **65,235.85** | **93.9** |
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 1,070,662.70 | 1,005,426.84 | 65,235.85 | 93.9 |
| 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж,урамшуулал | 131,858.00 | 131,858.00 | - | - |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

*Нэгдсэн судалгаанд хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнгийн талаар:*

1. Тус байгууллага нь бие даасан 100070012504 тоот төрийн сангийн дансанд ахмадын сангийн байршуулсан байна. Тайлант онд Цагаан сар, ахмадын өдрийг тохиолдуулан хүндэтгэл үзүүлэн бэлэг дурсгалын зүйл гардуулахад 1.7 сая төгрөгийг зарцуулж, сангийн үлдэгдэл 12.9 сая төгрөг байна.
2. Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.
3. Тайлант хугацаанд бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн /210801/ зардлын ангиллаар 14.3 сая төгрөгийн зарцуулалт гарсан байна.
4. Тайлант хугацаанд бараа үйлчилгээний бусад /210901/ зардлын ангиллаар 150.7 сая төгрөгийн зарцуулалт гарсан нь УИХ болон орон нутгийн сонгуулийн зохион байгуулалтын үйл ажиллагаа байна.
5. Орон тоог Улсын бүртгэлийн ерөнхий газраас хянасан дүнгээр 29 орон тоогоор төлөвлөн, бодит гүйцэтгэлээр 25 орон тоотой байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд орон нутгийн төсвөөс 57.6 сая төгрөгийн санхүүжилтийг авч албан хаагчдын орон нутагт ажилласны нэмэгдэл цалинд зарцуулсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу

Дорнод аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан консалтинг аудит ХХК-ийн аудитор Б.Үжин, аудиторын туслах Б.Саруулзаяа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Хаан консалтинг аудит ХХК-ийн чанарын хяналтын менежер Г.Ганцэцэг, Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах, аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар хэрэгжүүлсэн.

Дорнод аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хаан консалтинг аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 19/35 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын 823.9 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 16.5 сая төгрөгөөр тогтоосныг аудитын гүйцэтгэлийн явцад дахин хянаж 2024 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын 1,435.2 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 28.7 сая төгрөгөөр шинэчлэн тогтоох нь зохимжтой гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах ажлын хүрээнд тус байгууллага нь хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаагүй, үр дүн гүйцэтгэлийг тайлагнаагүй байна.

Аудитын явцад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой горим сорилыг хэрэгжүүлэхэд эрсдэлтэй асуудал гараагүй болно.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.